

# Манмин Мэдээ

Номер 22 2012 оны Тавдугаар сарын 6

## Нисси Оркестр байгуулагдсаны 20 жилийн ойн үйл ажиллагаа “Ариранг” тусгай тоглолт



“А-риран толгод дээрээс бидний Эзэнтэй уулзлаа” үзэсгэлэнт аялгуугаар Бурханыг магтаж буй хамгийн шилдэг магтаалын мэргэжлийн оркестр бүхий манай цуглаан нь Нисси оркестр байгуулагдсаны 20 жилийн ойн баярын үйл ажиллагаа өнгөрөгч гуравдугаар сарын 4-нд, үдээс хойш мөргөлийн үеэр Америк магтаал дуунд байдаг “Ариранг” төрөл бүрийн хэлбэрээр тоглож итгэгчдийн сэтгэлд ихэд нийцсэн тул дахиулан тоглуулж байлаа. Нисси оркестр нь 1992 оны 3-р сарын 1-нд, Жу Куан хёон удирдаачтайгаар анх байгуулагдаж гадаадын нэгдсэн их цуглаан, төдийгүй орон нутаг дахь магтаалын наадам болон сүмүүдийн хамтарсан үйл ажиллагаа сайн мэдээ тараах өдөрлөгийн тоглолт гэх мэт тоглолтуудад оролцож авралын зар тараах үйлсэд болон Христийн урлаг соёлын хөгжилд жинтэй хувь нэмэр оруулсаар ирсэн билээ.

## GCN -ны нэвтрүүлгээр дэлхийг даяарчлах хүчит үйлс “2012 оны NRB чуулга уулзалт болон үзэсгэлэн яармаг”

Ариун сайн мэдээ ба эрх мэдэлт хүчийг агуулсан HD болон 3D дүрс бичлэг нэвтрүүлэг зэрэг төрөл бүрийн хөтөлбөр бүхий GCN ТВ нь (ерөнхий захирал Доктор И Жей руг пастор) өнгөрөгч Хоёрдугаар сарын 18-21-ны хооронд Америкийн Теннисе мужын Нешвилл хотын Гейлорд Оприланд зочид буудлын хүлээн авалтын ёслолын танхимд нээгдсэн 2012 оны NRB (Дэлхийн Христийн нэвтрүүлгийн нэгдсэн холбоо)-ны чуулга уулзалт болон үзэсгэлэн яармагт оролцоод ирсэн билээ.

NRB (Дэлхийн Христийн нэвтрүүлгийн нэгдсэн холбоо) нь телевизийн нэвтрүүлгээр дамжуулан авралын зар түгээдэг христчин хүмүүсийн цугларалтынхаа хувьд дэлхий нийтээр 1700 гаруй энэ төрлийн үйл ажиллагаа явуулдаг байгуулагууд нэгдэн, жил бүр чуулга уулзалт болон үзэсгэлэн яармаг зохион байгуулдаг уламжлалтай төдийгүй үүгээрээ дамжуулан өөрсдийн үйл ажиллагаагаар болон дэвшилтэт технологийг бусадтайгаа хуваалцан чуулдагаараа онцлог юм.

Энэ удаагийн үзэсгэлэн яармагт нийт 6,000 гаруй Христийн нэвтрүүлгийн ажилтанууд болон 200 гаруй Христийн телевиз болон

хэвлэл мэдээлэлийн албаныхан цугларсан юм. GCN ТВ нь өөрийн шинэ нэрээр GCN Хэвлэл Мэдээлэлийн Алба хэмээх нэрээр оролцсон билээ. Маш үзэсгэлэнтэй гоёмсогоор чимэглэн зассан сурталчилгааны байр ба самбар нь тэнд цуглаж үзэж сонирхсон хүмүүсийн анхаарлыг маш их татаж байлаа.

Үзэсгэлэн яармагт оролцож байгаа олон байгууллагууд өөрсдийн хөтөлбөр болон үйл ажиллагаагаа сурталчилан танилцуулж байхад GCN Хэвлэл мэдээлэлийн алба нь Доктор И Жей руг пасторын “Амийн үгс” хэмээх HD форматаар бэлтгэсэн видео хөтөлбөрийг үзүүлэн тэнд оролцсон үзэгч сонирхогч олондоо танилцуулан үзүүлж үүнээс гадна төрөл бүрийн үзүүлэн ба программуудыг үзэж сонирхсон хүн бүрийн сэтгэлийг өөрийн эрхгүй хөдөлгөж байлаа.

Ялангуяа тэнд тэнгэрийн орны үзэсгэлэнтэй байдлыг харуулсан “Хоньчны Өргөө” хэмээх 3D дүрс видео хөтөлбөр нь цор ганц байсан ба GCN ТВ-н өндөр чадварыг гайхан магтаагаж байлаа. Үүгээр дамжуулан Христийн нэвтрүүлэгт ийм технологийг нэвтрүүлснээр бусад ТВ-тэй өрсөлдөх чадвар бүхий

өндөр түвшний ТВ болохоо батлан харуулсан юм.

NRB-ын ерөнхий захирал Доктор Франк Вraith гуай, “Эрин зууны хөгжил дэвшлийг дагаад, сүүлийн үеийн шинэ технологи хэдий чухал ч гэсэн юу юунаас илүүтэй хүнийг өөрчилж, нөлөөлөх чадвартай нэвтрүүлэг хамгаас чухал юм. GCN ТВийн нэвтрүүлэг хөтөлбөр бүрт авралын зар тараах хүч нөлөө бий.” хэмээн өгүүлсэн юм.

Дэлхий шилдэг Христийн хөтөлбөр ба сурган хүмүүжүүлэх сэдэвт чөлөөт хэвлэл мэдээлэлийн хамгийн том номын сан болон нийгмийн халамж үйлчилгээний олон удаагийн шагнал хүртсэн “Трули Медиа Групп” (www.truli.net)-ын захирал Майкл Солонон, “GCN ТВийн төрөл бүрийн хөтөлбөрүүд ба И Жей руг пасторын сургаалыг дэлхий даяарх үзэгчдэд дэлгэрүүлэхийг хүсэж байна.” хэмээн хэлэн хамтран ажиллаж гэрээнд гарын үсэг зурав.

Үүнээс гадна Америкийн Лайф Зон ТВ болон Бразилийн SCT Олон улсын хэвлэл мэдээлэлийн алба гэх мэт байгуулагууд GCN-ны хөтөлбөрүүдийг үнэгүйгээр цацах гэрээ байгуулж, 6 улсын 15 Христийн тв болон хэвлэл

мэдээлэлийн албадтай хамтран ажиллахаар гэрээ байгууллаа.

GCN ТВ-ын нэгэн ажилтан, “Энэ удаагийн үзэсгэлэн яармагаар дамжуулаад GCN ТВ нь дэлхий дахинаа хэрхэн эрчимтэй өргөжин тэлж байгааг мэдэрсэн юм. Цаашдаа

бүх дэлхий даяарх Христийн телевизүүдийг нэгтгэж, дэлхийн хаанаас ч үзэх боломжтой, төрөл бүрийн хэл дээр орчуулагдах гарах хөтөлбөр бүхий глобал тв болохын төлөө шамдаж байна.” хэмээн хэлсэн юм.



GCN ТВ нь Амийн үг сургаал ба, Бурханы хүч чадлыг өндөр түвшний христийн урлаг соёлын хөтөлбөрүүдийг дэлхий даяарх 170-д орнуудад цацан нэвтрүүлдэг билээ. ■ Фото 1: 2012 NRB чуулга уулзалт болон үзэсгэлэн яармагт оролцож буй GCN ТВ-ын сурталчилах байр ■ Фото 2: NRB -ын удирдагч нар 3D видео хөтөлбөрийг үзэж сонирхож байгаа нь ■ Фото 3: 2012 Оны Үзэсгэлэн яармагийн ерөнхий төрх байдал

«Загалмайн Үг» цувралаас -(20)

# Есүсийн загалмайн дээр айлдсан эцсийн долоон үг (4)

“Есүс -Аав аа, Таны гарт Би сүнсээ даатгая гэж чанга дуугаар хашхирлаа. Үүнийг хэлээд Тэр амьсгалаа хураав” (Лук 23: 46).

Ихэнхи хүмүүс үхэх нь ойртох үед өөрийн амьдралаа эргэн харж гэр бүл болон ойр дотныхондоо гэрээслэл болгон захиас үг үлдээдэг. Үүний нэгэн адил хүн төрөлхтөнийг аврахаар ирсэн Есүс загалмайн дээр цовдлогдон амьсгал хураахын өмнө хэдэн үг айлдсан байдаг ба түүнийг нь “Загалмайн дээр айлдсан эцсийн долоон үгс” хэмээн нэрлэдэг билээ.

Бурханы Хүүгийн хувьд хүн төрөлхтөний аврах төлөвлөгөөг төгс гүйцэтгэсэн Есүсийн эцсийн долоон үгсээр дамжуулан Эзэний зүрх сэтгэлийг гүнээ ухаарснаараа Бурханы жинхэнэ үр хүүхэд болох билээ. Өнгөрсөн дугаараас үргэлжлүүлэн Есүсийн загалмайн дээр дурдсан долоо дохь буюу эцсийн үгсүүдийн талаар тайлбарлах болно.

## 1. Есүс чанга дуугаар “Ааваа” хэмээн дуудсаны учир

Лук 23: 46-д, “Есүс -Аав аа, Таны гарт Би сүнсээ даатгая гэж чанга дуугаар хашхирлаа. Үүнийг хэлээд Тэр амьсгалаа хураав” хэмээн өгүүлсэн байдаг. Тийнхүү чанга дуугаар “Ааваа” хэмээн хашхирсаны учир нь юу вэ?

Энэ нь Есүс эцсийн удаа айлдан үлдээж буй үгээ хүмүүст сонгохын тулд байсан ба мөн “чанга дуугаар хашхиран залбирах” нь Бурханы хүсэл болохыг мэдүүлэхийн тулд байсан юм.

Иеремиа 33: 3-д, “Намайг дууд, Би чамд хариулж, чиний мэдэхгүй аугаа хүчит зүйлийг Би чамд ярина” хэмээн айлдсан байдаг. (Тооллого 12: 13, Шастирын Дэд 32: 20, Дуулал 57: 2, Марк 10: 47, Иохан 11: 43, Үйлс 4: 24, Үйлс 7: 59).

Есүс Гетсемани цэцэрлэгт залбирах үедээ хөлс нь газарт унахдаа цусны дусал болтол чин сэтгэлээсээ залбирч байсан юм. Эмч нар үүнийг тайлбарлахдаа хүн ямар нэгэн зүйлд бүх анхаарлаа хандуулан хэт ачаалал өгсөн үйлдлийн улмаас хялгасан судас хагарч, арьсан дахь хөлсний сувгаар цус холилдон гарах боломжтой хэмээн дүгнэсэн байдаг. Ялангуяа Израйль мэт цөлийн цаг агаар шиг нөхцөлд, тэнд шөнөдөө хүйтэн сэрүүн үед ч Есүс хөлсөө дуслуулах хэмжээний чангаар дуудан чин сэтгэлээсээ залбирсан учраас цусны дусал мэт хөлс гарсан билээ.

## 2. “Таны гарт Би сүнсээ даатгая” хэмээн айлдсаны учир

1) Сүнс бол үхэшгүй мөнх зүйл гэдгийг гэрчилдэг

Есүс амьсгалаа хураах үедээ чанга дуугаар, “Есүс -Аав аа, Таны гарт Би сүнсээ даатгая” хэмээн айлддаг. Загалмайд цовдлогдон махан биений амь тасарсан ч гэсэн Түүний сүнс нь мөхөж устахгүй бөгөөд Эцэг Бурхандаа очсон билээ. Хүн нь сүнс, сэтгэл бие махбодийн нэгдэлээс бүрддэг. Хүний бие махбод нь сүнс сэтгэлийг агуулж буй хальс гадарга төдий зүйл бөгөөд хэрэв махан бие нь үхвэл шороо руугаа буцдаг бол харин сүнс нь үхэшгүй мөнхөд байдаг ба



Доктор И Жей руг Тэргүүн Пастор

ушташгүй зүйл юм.

Бурхан шороогоор Адамын биеийг бүтээгээд хамраар нь амийн амьсгалийн үлээж оруулсанд амийн үр, өөрөөр хэлбэл Адамын сүнс бий болсон юм. Бурхан Адамын сүнсэнд сүнсний мэдлэг өөрөөр хэлбэл үнэний мэдлэгийг дүүргэж өгсөн билээ. Ингэж амийн үрийг үнэний мэдлэгүүдээр дүүрэн буй сүнс нь Адамын зүрх сэтгэл юм.

“Сэтгэл, сэтгэхүй” гэдэг нь хүний уураг тархин дахь ой санамжинд агуулагдсан мэдээлэл ба үүнийгээ эргэн санан бодож, мэдрэх бүх үйл явцыг ерөнхийд нь нэрлэдэг юм

Анхандаа Адамын сүнс нь сэтгэл болон биеийг удирддаг байв. Сүнс нь үнэнээр дүүрэн учраас сүнсний удирдлага дотор сэтгэл ба бие ч үнэний дотор хөдөлдөг байлаа.

Гэвч Адам сайн мууг мэдүүлэгч модны жимснээс идэн Бурханы тушаалыг зөрчсөнөөс болж Түүний сүнс нь үхмэл болсон юм. Сүнсний үхмэл байдал гэдэг нь Бурхантай харьцаатай байсан харилцаа холбоо нь тасран идэвхитэй үйл ажиллагаагүй болно гэсэн үг юм. Хүний төв удирдлага болох сүнс нь үхэж, зогсонги байдалтай болсоноор оронд нь сэтгэл нь сүнсний оронд биеийг удирдаж эхэлсэн ба сэтгэл дайсан сатан диаволын нөлөөн дор худал хуурмагийн мэдлэгүүдийг хүлээн авч эхэлдэгийг харж болно. Ингэж зүрх сэтгэлд худал хуурмагийн мэдлэгүүдээр дүүрэх тусам анх Бурханаас суулгаж өгсөн үнэний мэдлэг нь алдагдах болсон юм. Хайр энэрэл, төлөв даруу байдал, бусдын эрх ашгийн төлөө гэх сэтгэл нь гарч үзэн ядалт, уур, амин хувиа хичээх сэтгэлээр дүүргэгдсэн байдалтай болсон билээ.

Ийм худал хуурмагийн мэдлэгүүд нь амийн үрийг бүрхэж хэвийн үйл ажиллагаа явуулахад саад болж хүлсэн байдалтай болсон учраас сүнс нь үхмэл болсон гэж нэрлэсэн юм. Хэдийгээр сүнс ийм үхмэл, зогсонги байдалтай болсон ч гэсэн хүний сүнс нь бүр устаж үгүй болох боломжгүй бөгөөд хүний сүнс нь мөнхөд орших Бурханаас гаралтай ба Бурхан хүнд амийг амьсгалаар үлээж оруулан сүнснийг бий болгосон учраас юм.

Тэгвэл хүний бие үхвэл сэтгэл хаашаа

явах вэ? Уураг тархи байснаараа түүний эд эсээр дамжуулан бодож сэтгэж, эргэн санаж байдаг. Тэгтэл бие үхэхэд уураг тархи ч ой санамж ч ажиллагаагүй болон үхэж сүнсгүй амьтны бие ба тархи нь үхсэнээр төгс устаж үгүй болдог. Гэвч сүнсгүй оршин байгч хүн нь сэтгэл сэтгэхүйн үйл ажиллагаа нь зүрх сэтгэлд хадгалагдан үлдэх учраас сэтгэл санаа нь үхэж усталгүй сүнс доторхи сэтгэл санааны байдал болж нэгддэг билээ. Өөрөөр хэлбэл сүнс сэтгэл 2 нэгдмэл байдалтай мөнхөд оршино гэсэн үг юм. Тийм ч учраас Их Эзэн маань, “Аав аа, Таны гарт Би сүнсээ даатгая”. хэмээн айлдсан билээ.

Хүн авралын зарыг сонсоод Есүс Христийг итгэн хүлээж авч, Ариун сүнс авах болдог ба ингэснээрээ үхмэл байсан сүнс нь амилдаг билээ. Тэгээд дахин Бурхантай холбогдох болж, зүрх сэтгэлдээ үнэний мэдлэгээр тэжээгдэн дүүрэх тусам худал хуурмагыг авч хаях боломжтой болсон юм. Үнэн зөвт байдал зүрх сэтгэлд дүүрэн бол үнэн дотор бодож сэтгэн, үнэнийг л үйлдэх юм.

Ингэж сүнс нь эргэн амилж, зүрх сэтгэл нь үнэн зөвт байдлаар дүүрсэн хүнийг “Сүнс сэтгэл нь амжилттай” гэдэг ба сүнс сэтгэл амжилттай байх тусам, өөрөөр хэлбэл зүрх сэтгэл нь үнэнээр дүүрэх тусам бүх зүйлд амжилттай эрүүл энхийн ерөөлийг эдлэх болдог. Хайрт минь, сэтгэл тань амжилттай байгаагийн адил аливаа үйлс тань сайн сайхан байж, эрүүл энх байгаасай” хэмээн би залбирч байна. (3 Иохан 1: 2).

Иохан 3:5-д Есүс, “-Үнэнээр, үнэнээр Би чамд хэлье. Хэн ус болон Сүнснээс эс төрнө, тэр хүн Бурханы хаанчлалд орж чадахгүй” хэмээн айлдсан байдаг. Ариун Сүнс болон усаар дахин төрсөн хүмүүс өөрөөр хэлбэл сүнс нь амилсан хүмүүс л тэнгэрийн орох болдог. Тиймд, Есүс Христэд итгэлгүйгээр сүнс нь амилахгүй бөгөөд үнэний зүрх сэтгэлээр өөрчлөгдөх боломжгүй учир тэнгэрийн оронд орж чадахгүй билээ.

Ийм хүмүүсийн төлөө бэлтгэгдсэн газар нь там бөгөөд тэдгээр хүмүүс нь гэмт нүглийнхээ улмаас дайсан муу ёрын сүнсний хамт мөнхөд тамын галд шидэгдэн тэндээ тарчлах болдог.

2) Есүс зөвхөн Бурханы хүслийн дагуу бүх зүйлийг дуулгавартайгаар биелүүлснийг гэрчилдэг.

Есүс “Таны гарт Би сүнсээ даатгая” хэмээн залбирал өргөдөг нь Есүс зөвхөн Бурханы хүслийн дагуу бүх зүйлийг дуулгавартайгаар биелүүлснийг гэрчилдэг юм.

Есүс энэ газарт буун ирсэн нь, загалмайд цовдлогдон нас баран, дахин амилах ч гэсэн Есүс Өөрийн хүсэл ба төлөвлөгөөний дагуу болсон зүйл биш бөгөөд үхэл амьдралыг удирдан хүн төрөлхтөний бүх үйл явцыг жолоодон буй Бурханы хүслийн дагуу бүгд биелэгдсэн юм. (Иохан 4:34). Тиймд бид Есүс Христийн нэрээр залбирал хийдэг ч хариулж өгдөг нь Бурхан билээ.

Матай 10: 29-31-д, “Хоёр бор шувууг задгай зоосоор худалддаг биш үү? Эцэгийн тань зөвшөөрөлгүйгээр тэдний нэг нь ч газарт унахгүй. Та нарын толгой дээрх ширхэг үсийг чинь хүртэл бүгдийг нь тоолсон байна. Иймээс бүү ай! Та нар олон бор шувуунаас ч илүү үнэтэй.” хэмээн айлдсан байдаг. Эрхэм та сэтгэл зүрхэндээ энэ үгийн сүнс зүгийн утгыг ухаарч, сэтгэл зүрхнээ гүнээ суулгавал, та бүхэн бүх зүйлээ Бурхандаа даатгаж чадах билээ.

Нэг бор шувуу ч гэсэн Бурханы зөвшөөрөлгүйгээр газарт унахгүй бөгөөд бидний толгойн үсийг хүртэл тоолсон хэмээн айлдсанчлан үнэхээр итгэлээрээ Бурханд найддаг бол өвчний асуудал болон ажлын амжилт, мөн Бурханы ажлыг гүйцэтгэхэд ч хариулт авч чадахгүй зүйл байхгүй билээ.

Есүс нь уг гаралаараа Бурханы нэг бөгөөд гурвын холбооны Бурханы нэг нь байсан ч гэсэн зөвхөн Бурханы хүсэл зорилгын төлөө байсан ба Бурханд л бүх зүйлээ даатгасан юм. Үүний адил та бүхэн ч гэсэн хүний арга болон хүнд найдалгүй зөвхөн Бурханд найдан түшиглэж, хүний хүч чадалтай харьцуулшгүй Бурханы хүчит үйлсийг үргэлж мэдэрч Бурхандаа алдрыг өргөхийг хүсэж байна.

Хайрт итгэгч ах эгч дүү нар минь Загалмай дээр айлдсан эцсийн долоон үгийг үргэлж санан, аймшигт загалмайн зовлонг эдлэж байхдаа ч чанга дуугаар хашхиран байж айлдсан Есүсийн бидэн рүү хандсан сэтгэлийг гүнээ ухаарч Бурханы хүслийг төгс биелүүлэн дахин ирэх Эзэний хүсэн тэмүүлж бүх хүмүүстэй хамт сүр жавхлалт зөвт байдлын титмийг авахыг Их Эзэн нэрээр хүсэн ерөөе!

Mongolian

Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

235-3 Гуро-Здонг, Гуро-гу, Сеул,  
152-848 Солонгос Улс  
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048  
<http://www.manmin.org/english>  
e-mail: [manminministry@hotmail.com](mailto:manminministry@hotmail.com)

Нийтлүүлэгч: Жаерок Лее  
Редактор: Геумсун Вин

# Аз жаргал ба чухал ач холбогдол бүхий ММБТ-н олон улсын бэлтгэл хөтөлбөр

Манай Манмин Төв Сүмийн ММБТ (Манмин Миссионер бэлтгэх төв)-д өнгөрөгч 2-р сарын 3-наас 27-ны хооронд болж “Олон улсын бэлтгэл хөтөлбөр” болж өнгөрлөө. Энэ удаагийн хөтөлбөрт АНУ, Израйль, Орос, Испани, Хятад, Тайланд, Вьетнам, Казакстан, Непаль болон Индонейз гэх зэрэг арван орноос ирж оролцсон бөгөөд оролцогчид бүгдээрээ тус хөтөлбөрийн үйл ажиллагаа гайхамшигтай сайхан болж өнгөрлөө хэмээн маш сэтгэл хангалуун байв. Эдгээр оролцогчид нь өөрсдийн эх орондоо буцаж очоод ариун сайн мэдээ ба эрх мэдэлт хүчний нөлөөгөөр сүм чуулганаа сэргээн, үхэж буй олон хүмүүсийг аварья гэсэн халуун сэтгэлээр дүүрэн байлаа. Хоёрдугаар сарын 23-нд эдгээр оролцогчид Доктор И Жей руг пасторын залбирлаар далайн шорвог ус амтат ус болон (Египетээс гарсан нь 15:25) хувирсан Мүан амтат усны хүрээлэнд зочлон Бурхандаа талархал ба алдрыг өргөн барьцаасан юм.

## “Бурханы хүч чадал зайлшгүй нөлөөлсөн болохыг мэдсэн юм.”



**Алхерито Акерина**  
(Индонейз,  
Палембанг Сүм бэлтгэл номлогч)



◆ 2008 онд би Доктор И Жей руг пасторын эрх мэдэлт хүчит үйлс бүхий DVD-г үзсэн юм. Миний сэтгэл маш их хөдөлж нулимс хүртэл унагааж байсан ба таван удаа дахин үзэх хэмжээний бялхал болон маш их ивээл хүртсэн юм. Тэр эрх мэдэл бүхий агуу хүчит үйлсүүд нь миний мэддэг байсан алдартай пасторуудаас хамаагүй өөр байв.

Би маш их хүсэн тэмүүлсний эцэст энэ удаагийн сургалтанд оролцох боломжтой болсон ба Манмин Төв Сүмд өөрийн биеэр очиж үзэж танилцсанаар олон зүйлийг сурсан. Ялангуяа сургалтын хөтөлбөрт багтсан “Угийн дуу хоолой” хэмээх видео лекцээр дамжуулан Бурхан Доктор И Жей руг пасторт ийм хэмжээний эрх мэдэлт хүч өгөхөөс аргагүй байжээ гэсэн гайхалтай үнэнийг олж мэдсэн.

Энэ бол өөрөөр хэлбэл Эзэнийг дуурайсан жинхэнэ үр хүүхдийг хүсэж буй Бурханы зүрх сэтгэл ба хайрыг гүнээ ухаарсан Доктор И Жей руг пастор Бурханыг хайрлаж баярлуулах итгэлийн хэмжээнд хүрсэн учраас ийм хүчийг хүртсэн юм. Мөн Бурханы зүрх сэтгэл ба хайрыг ухаарах үед бидний итгэл ч гүнзгий түвшин рүү ордог болохыг мэдсэн юм.

## “Мүан амтат усанд орсны дараа миний хоёр чих сайн сонсож эхлэв”



**Кейби Бахадур Рай итгэгч**  
(Непаль Манмин Сайн мэдээ төвийн  
Эрэгтэйчүүдийн багийн удирдагч)



◆ Би Доктор И Жей руг пасторын Загалмайн Үг болон Итгэлийн Хэмжээ хэмээх Непаль хэл дээр орчуулагдсан номуудыг уншаад би маш ивээл авсан юм. Ялангуяа түүний “Миний амьдрал Миний Итгэл” хэмээх ном нь надад итгэл болон өөрийн итгэлээ эргэн харах боломжыг олгосон юм.

Өнгөрсөн жилээс эхлэн би хариуцагч И Хэй чон пасторийн Непал Манмин Сайн мэдээ төвийн ажиллаж, салбар сүмүүдийн үйл ажиллагаа ба семинаруудын үйл ажиллагаа болон бэлтгэл ажилд туслан ажиллаж байгаа билээ. Чадварлаг ажилтан болохоор энэ удаагийн сургалтанд оролцсон би Солонгост ирэхийн өмнө өдөр бүр 2 цаг залбирал хүсэн тэмүүлэн бэлдэж ирсэн билээ.

Бүхий л сургалтын хөтөлбөрүүд нь үнэхээр миний сэтгэл хөдөлгөсөн аз жаргалтай хором байлаа. Мөн Мүан амтат усны хүрээлэнд зочлон гайхамшигтай эрх мэдэлт хүч нөлөөг биеэр мэдрэх боломж олдсон юм. Мүан амтат усанд булхахын 7 төрлийн зүрх сэтгэлийн хүсэлтээ бодон чин сэтгэлээсээ залбирсаны дараа орсон. Тэр үед амтат ус чихэнд минь орон чихэн дотор халуун бүлээн болж байгааг мэдэрсэн юм. Үүний дараа амтат уснаас гарч ирэхэд миний хоёр чих сайн сонсодог болж өмнөхөөсөө илүү сайн тод сонсодог болов. Халлеллуяа!

## “Даниел залбирлын цагаар дамжуулан залбирлын жинхэнэ амтыг олж мэдэв”



**Алекс Абанкин итгэгч**  
(АНУ-ын Мелхизедек Сүмийн  
бүлгийн цуглааны удирдагч)



◆ 1 жилийн өмнө миний итгэлийн амьдрал зогсонги хоосон цагыг өнгөрөөж байлаа. Тэр үед Доктор И Жей руг пасторын ном “Загалмайн Үг”, “Итгэлийн Хэмжээ”, “Тэнгэрийн орон I ба II”, “Там”, болон “Миний Амьдрал Миний Итгэл” хэмээх номуудыг уншсан юм. Тэдгээр номуудад миний олж мэдэхийг туйлаас их хүсч байдаг зүйлсүүдийг нарийн дурдан бичсэн байв. Тэдгээр номуудаар дамжуулан их ивээл хүртэн ариун сайн мэдээг илүү гүнзгий сурахын тулд энэ удаагийн сургалтанд оролцохоор шийдсэн.

Доктор И Жей руг пастор нь Америкт амьдардаг олон мянган Словак хүмүүсийн дунд эрх мэдэлт хүчтэй Бурханы хүн гэдгээрээ алдартай билээ. Мөн тэрээр ямагт итгэгч нартаа үйлчилдэг даруухан дүр төрх миний гишүүд энэ пасторыг ихэд хүндэтгэн хайрлаж, Бурханы үг түүний заасан сургаалуудын дагуу үйлдэн тэнгэрийн орны тэмүүлэлээр бялхам байдлыг хараад надад маш сайхан санагдсан юм. Бас залбирлын сэдвүүдээ бичиж тэмдэглээд орой бүр Даниел залбирлын цагт оролцсоноор Бурханы хүсэж буй залбиралыг хийх боломжтой болсон.

## “Эзэний баярлан таалах магтаал гэж юу болохыг олж мэдсэн юм”



**Лили Бочарников**  
(Израйль Назарет амийн сүм  
магтаалын удирдагч)



◆ Би ММБТ-н олон улсын бэлтгэл хөтөлбөрт өөрийгөө болон сүм чуулганаа хөгжүүлэхийн тулд олон зүйлийг сурах болно гэж найдан оролцсон юм.

Юуны өмнө 2009 онд Израйлийн нийслэл Иерусалим хотод Израйлийн нэгдсэн их цуглааны зохион байгуулж олон мянган итгэгчдийг сэргээсэн Манмин Төв Сүмийнхэнд болон Доктор И Жей руг пасторт талархсанаа илэрхийлэв. Энэ мэт чухал том ажлыг хийсэн Манмин Төв Сүмд өөрийн биеэр ирээд сүнс зүгийн үг сургаалиар зэвсэглэн, залбирлын дасгалжуулалтыг авах нь миний хувьд нэр төрийн хэрэг билээ. Би магтаалын удирдагч болохоор магтаал дуу бүжгийн хэсгийн багш нар магтаал дуу, вошип түүнд хэрэглэгдэх хэрэгсэл болон хувцаслалт, зэргээр хичээл ороход олон зүйлийг ойлгон сурч, их ивээл авсан юм. Эдгээр эрхэм багш нарын тоглолтын талаарх хичээлүүдийг хичээнгүйлэн камертаа бичлэг хийж авсан юм. Эндээс сурч мэдэж авсан зүйлсээ сайн ашиглаж Эзэний баярлан таалан хүлээн авах магтаалыг өргөж, ариун сайн мэдээг идэвхитэй сайн тараахыг хүсэж байна. Энэхүү сургалт нь миний хувьд агуу их ерөөлийн цаг байлаа.



Оролцогчдын Фото Зурагнууд ■ Фото 1: Хичээлдээ шимтэн сууж буй оролцогчид ■ Фото 2: Баасан гаригын Оройн цуглаанд бялхал дүүрэн магтаал ■ Фото 3: Даниел залбирлын цагаар ■ Фото 4: Манмин залбиралын төвийн “Эдгэрэл ивээлийн цуглаан”-ы үеэр ■ Фото 5: Мүан амтат усны хүрээлэн дэх Магтан дуу ба залбиралын цуглааны үеэр ■ Фото 6: Мүан амтат усны хүрээлэн дэх тусгай цаг ■ Фото 7: Мүан амтат усны хүрээлэн дэх Магтаал ба шийдвэр гаргах цаг ■ Фото 8: GCN ТВ дээр хийсэн айлчлал ■ Фото 9: Хоёрдугаар сарын 26-нд болсон Төгсөлтийн үйл ажиллагаа

### Улаанбаатар Манмин Сүм

#### Мөргөлийн цагийн хуваарь

#### залбирал цагийн хуваарь

Мөргөл	Цаг	Ангилал	Цаг	Удирдагч
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10: 30	Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11: 30			
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18: 00	Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21: 30			
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09: 00	Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15: 00			
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17: 00			

Манай хаяг:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 12-р хороо, Хангайн 3-57 тоот  
Улаанбаатар Ариун баярт мэдээ чуулган

Чуулганы утас: 976-11-351437

Чуулганы хариуцсан төлөөлөгч:

Г. Анхбаяр СМТ 976-91173712

976-91615337

Е- шуудан : power3712@gmail.com

# “Эзэний хайраар туйлдсан амьдралаа ялан дийлэх боломжтой болсон юм.”

Ким Кёон сүг Сүмд үйлчилэгч (эмэгтэй, Зүүн Куанжу Манмин сүм)



2003 оны Аравдугаар сард би нас дээр гарсан ч нөхөр болох Со Ёон дог сүмд үйлчлэгчтэй хурим хийсэн юм. Би хадам эцэг эхдээ сайн үйлчилье гэсэн сэтгэлээр үйлддэг байсан насны ялгаа болон зан аашнаас болж хадам эхтэйгээ таарахгүй зөвхөн стресс л хуримтлагдсаар байв. Миний нөхөр үүнийг мэдэж байсан боловч туслах ямар ч боломжгүй байв.

Хадам эхтэйгээ таарахгүйгээсээ болж ганцаардах өвчин болон бусад өвчнөөр зовж байхад...

2005 оны Гуравдугаар сард би анхны бэр байсан ба хоёр ихэр хөөрхөн хүү төрүүлсэн боловч хадам эх маань надад бас л дургүй хэвээрээ байв. Иймд надад гомдоллох сэтгэл төрж, бүх зүйлийг хадам эхийн хүслээр амьдарна гэдэг үнэхээр хүнд асуудал байлаа.

“Би яагаад ингэж амьдрах ёстой гэж? Амьдрал утгагүй, сонирхолгүй, үнэхээр ганцаардаж байна?” “Би нөхрөөсөө салдаг ч юм билүү?” хэмээн ийм тийм бодолд автаж эхлэв.

Эцэст нь ганцаардах өвчин минь улам хүндэрч, сайн унтаж ч чадалгүй байнга хар даран зүүдэлж байлаа. Хааяа хайч хэрэглэн муу сүнс болон чөтгөрийг ч хардаг боллоо. Одоо эргэн бодоод байхнээ тэр үед зүрх сэтгэл минь сайн биш байсан болон эцэг эхийн маань хиймэл шүтээн шүтдэг байсан нь тийнхүү надад бас нөлөөлдөг байлаа.

Дээрээс нь нэмж төрөлтийн дараах үрэвслээр нуруу болон зүүн хөл маань өвдөж эхлэв. 2009 онд нуруу нугасны төрөлжсөн эмнэлэгт MRI рентгени зураг авахуулж хариу нь нурууны диск өвчтэй гэсэн онош гарсан юм. Ихэр хүүхдүүдээ харж хандах болон мөнгөний боломжгүй байдлаас болоод хагалганд орох боломжгүй байв. Нурууны айхтар өвдөлт болон сэтгэлийн хямрал ганцаардалын байдлаасаа болоод ингэж зовж байснаас үхэх юм сан гэж боддог байлаа.

Гар алчуурын цуглаанд оролцон, Ариун сүнсний галаар эдгэрэл аваад...

2009 оны Аравдугаар сарын нэгэн өдөр хайрын Их Эзэн маань миний амьдралд ирэв. Үргэлж намайг номлож байдаг манай хажуу хөрш айлын Жон Жин гёон сүмд үйлчлэгч гэнэт санаанд оров. Тэр хажуу айлын эгч маань надад урьд нь Манмин Төв Сүмийн вэб сайтаар орж үзүүлэн Доктор И Жей руг пасторын залбирлаар арьсны болон үе мөчний өвчнүүд үүнээс гадна маш олон төрлийн өвчнөөсөө эдгэрсэн маш олон хүмүүсийн гэрчлэлүүдийг үзүүлж байсан юм.

Тэгээд би Жон сүмд үйлчлэгчийн тусламжтайгаар Зүүн Куанжу Манмин сүм руу явах боллоо. Тэр сүмд би ороод суумагцаа яагаад ч юм нулимс гарч, нүүрний будагтай холилдон урсав. Түүний дараа, Жон Ёон уг пастор манай гэрт хүрч ирэн гэрийн цуглаан хийсэн юм. Тэр үед надад гар алчуураар залбирал хийж өгсөн юм. (Үйлс 19:11-12). Үүний дараа би хар дарж зүүдлэх болон сэтгэлийн хямралаасаа нэлээд их дээрдсэн юм.

Сүмд яваад хоёр сар болж байхад И Хи сон пасторыг урсан гар алчуурын цуглаан болж би түүнд оролцсон юм. Пастор ариун сүнсний бялхал дотор миний зүрх сэтгэлийн байдлыг сайн ойлгож байсан ба түүнчлэн залбирал хийж өгсөн билээ. Хайрын Бурхан миний сэтгэлийг мэдэж, тайтгаруулж байгааг мэдэрч эцэс төгсгөлгүй мэт нулимс унагаах байлаа.

Бурханд итгэхээс өмнө дэлхий ертөнцийн зүйлтэй хутгалдан амьдарсан өнгөрсөн амьдралаа бүгдийг гэмшсэн юм. Энэ үед Ариун Сүнсний гал миний толгой руу орох шиг мэдрэгдэж, хамаг бие халуу төөнөн хөлс гарч байлаа.

Тэр шөнөдөө нэгэн гайхамшигт зүйл тохиолдов. Хэзээ ийм байлаа гэх хэмжээний үнэхээр сайхан тайван унтсан ба өглөө босоход бүх бие минь сэргэж сайхан өглөөтэй учиран золголоо. Дараагийн өдөр нь гадуур явж байхдаа ямар нэгэн зүйл миний хөлөөс минь гарч байгааг мэдрэв. Тэр нь миний нурууны диск өвчнөөсөө эдгэрч байгаагийн илрэл байв. Үүний дараа биеийн дасгал хүссэнээрээ хийдэг болж, ямар ч зовиургүй болсон байв. Түүнчлэн сэтгэлийн хямрал, хар даран зүүдлэх болон бусад бие махбодийн сул дорой маань бүр мөсөн алга болов. Халлелуяа!

Гэр бүлээрээ итгэгч болон аз жаргалтай амьдарч байна

Илүү талархалтай зүйл нь миний шархалсан зүрх сэтгэл минь эдгэрч өөрчлөгдөж байгааг явдал юм. Сургаалиар дамжуулан хадам эхдээ өөрийн бүх зүйлээ зориулсан Рутын сайхан сэтгэл, Бурханы баярлан таалах эв нэгдэлтэй байх, үйлчлэх сэтгэл, хайр зэргүүдийг ухааран, миний сэтгэлд гомдоллох, үзэн ядах, бухимдах болон олон зүйлсэд автагдсан байгаагаар олж мэдэв. Хадам эх ба бэр хоорондын зөрчил, сэтгэлийн хямрал, нойргүйтэх өвчин, зүрх сэтгэлийн шарх зэрэг нь бүгд надаас болсон гэдгийг хүлээн зөвшөөрч чин сэтгэлээсээ гэмшсэн юм. Мөн нөхрөө үл тоон буруу авирлаж байсандаа хүртэл гэмшлээ.

Энэ мэт мацаг барин залбирангаа өөрчлөгдсөн зүрх сэтгэлээр хадам эх болон нөхөртөө хандсанаар тэдэнтэйгээ эвлэрсэн юм. Буддын сүм дуган руу явдаг байсан миний ээж маань ч миний гэрчлэлийг сонсоод сүмд очдог болов. Одоо манай гэр бүлийнхэн бүгд сүмд очдог болж гэр бүлээрээ итгэгч болох ерөөлийг хүртэн илүү их аз жаргалтай байна.

Сүүлийн үед Бурханы надад өгсөн ивээлийг бодон талархалын нулимс урсгадаг болов. Сүнс бие сэтгэлийг эдгээж өгч, гэр бүлийг минь эв нэгдэлтэй болгосон төдийгүй тэнгэрийн орон Шинэ Иерусалим руу тэмүүлэн давших ерөөлийг хайрласан Бурхандаа бүхий талархал ба алдрыг өргөө!

## Үнэхээр Гайхамшигтай зүйлийг биеэр мэдэрсэн билээ!

Оюунчимэг итгэгч (Эмэгтэй, Монголын Манмин Сүм)

Би цусны их даралттай ба, 20-д жилийн турш толгой өвддөг, мөн хөлөн дээрээ алерги экзем болон элэгний гепатит С-н өвчтэй учир үргэлж эмээр амьдардаг байв. Түүнчлэн, бөөр муу тул байнга 00-н өрөө рүү явдаг байсан нуруу минь ч байнга өвддөг байв.

2009 оны Арванхоёрдугаар сарын 31-нд, би Монголын Манмин Сүмд ирж Бурханы хайрыг аван аз жаргалтай итгэлийн амьдралаар амьдарч байлаа. 2010 оны Тавдугаар сард Жү Хёон гуан пасторыг урьсан “Монголын Манмин Сүмийн 7-н жилийн ойн баяр болон гар алчуурын цуглаан” болох тухай мэдээг сонсов.

Би тэр цуглаанд оролцон сургаал сонсож байхдаа өнгөрсөн амьдралаа эргэн хиймэл шүтээнд мөргөж байснаа гэмшсэний дараа гар алчуурын залбирал (Үйлс 19:11-12) авсан юм. Яг тэр үед миний бүх биеэр халуу төөнөн зүрх сэтгэл минь амар тайван болсон юм. Тэр үеэс хойш миний бие сайжирч, олон өвчнөөсөө эдгэрч, мөн Монголын Манмин Сүмийн хариуцагч Батзориг Сайн мэдээ тунхаглагчийн удирдсан гар алчуурын цуглаануудад оролцон залбирал аван ивээл хүртсээр байлаа.

2010 оны Долдугаар сард би нэгэн өдөр гайхамшигт зүйлтэй учирав. Үүрийн 3 цагын орчим надад нэгэн зүүд зүүдэлсэн юм. Тэр зүүдэнд Манмин Төв Сүмийн Тэргүүн пастор Доктор И Жей руг пастор Ням гариг Эзэний өдрийн их мөргөлийн адислалыг хийж байгаагаар зүүдэлж байсан ба гэтэл гэнэт гадаа “пан!” “пан!” гэсэн чанга дууг сонсов. Би ч маш гайхан босч гадаа юу болоод байгааг харахаар гарав. Би байранд орцны жижүүр хийдэг ба миний хариуцагч байсан газарт үнэтэй машинуудын ойролцоо 1метр гал гарч байгааг олж харав. Би ч маш хурдан очин галыг усаар унтраав. Хэрэв би бага зэрэг оройтсон байсан бол тэдгээр үнэтэй машинуудад гал дамжин том хэмжээний түймэр болох байсан бизээ. Гэвч Бурхан надад эдгээр зүйлээс сэрэмжлүүлэн чанга дууг сонгож өгснөөр энэ үйл явдлыг бага дээр нь шийдвэрлэх боломжыг олгосон билээ. Одоо ч гэсэн энэ талаар эргэн бодохдоо Бурханы ивээлд үргэлж талархан баярлаж явдаг билээ.

Сайн Бурхан Аавдаа бүхий л талархал ба алдрыг өргөө!




### Монгол Манмин Төв Сүм

#### Мөргөлийн цаг

Мөргөл	Цаг
Их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшх мөргөл	Ням гариг 13: 40
3-дахь өдрийн мөргөл	3 дахь өдөр 18: 00
5-дахь өдрийн мөргөл	5 дахь өдөр 22: 00
Хүүхдийн мөргөл	ням гариг 10: 30
Сурагч залуучуудын мөргөл	Хагас сайн өдөр 16: 30

#### Залбирлын цаг

Ангилал	Цаг	Удирдагч
Даниел үүрийн залбирал	Даваа- баасан 05: 00- 06: 00	Ш. Золзаяа (Том хүний баг хариуцагч)
Даниел өдрийн залбирал	Даваа- баасан 09: 00- 10: 00	П. Уртнасан (2Том хүний баг хариуцагч)
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18: 30- 20: 00	П. Батзориг (Чуулганы хариуцагч)



**Хаяг:** Баянзүрх дүүрэг, 13-р хороолол 6-р хороо, ой булан- 6 иргэний А.О.С  
**Утас:** чуулганы- 5525-7637 чуулганы хариуцагч- П. Батзориг 9117-0773

www.manmin.org  
www.manmintv.org